


БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ-5

Банкны салбарын шинэчлэлтэй холбоотойгоор системийн нөлөө бүхий банкууд хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд хувьцаагаа арилжаалж эхлээд байгаа билээ. Үүнтэй холбоотойгоор бидний зүгээс банкны салбарын гол үзүүлэлтүүдийн талаар 7 хоног бүр нэгтгэн харилцагч, хөрөнгө оруулагч нартаа хүргэж буй. Энэ 7 хоногт бид банкны ЭХ ҮҮСВЭР-ийн талаар мэдээлэл бэлтгэлээ.

БАНКУУДЫН ЭХ ҮҮСВЭР

Нийт банкуудын эх үүсвэр, их наяд төгрөг



2022 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын хөрөнгийн эх үүсвэрийн нийт хэмжээ 40.9 их наяд төгрөгт хүрсэн байна.

Үүнээс 27% буюу 10.9 их наяд төгрөг нь ААН-ийн харилцах дансанд, 41% буюу 16.7 их наяд төгрөг нь Хадгаламж хэлбэрээр, 12% буюу 5 их наяд төгрөг нь Гадаад банк санхүүгийн байгууллагын харилцах болон хадгаламж хэлбэрээр, 7% буюу 2.9 их наяд

төгрөг нь Төв банканд өгөх өглөг хэлбэрээр, 3% буюу 1.3 их наяд төгрөг нь Засгийн газарт өгөх өглөг хэлбэрээр, 2.9% буюу 1.2 их наяд төгрөг нь бусад банканд төлөх өглөг хэлбэрээр, 2.4% буюу 1 их наяд төгрөг нь Санхүүгийн байгууллагад өгөх өглөг хэлбэрээр илэрхийлэгдсэн байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд банкуудын нийт эх үүсвэрийн хэмжээ 11.3 их наяд төгрөгөөр буюу 38.3% -иар өсчээ. Мөн хугацаанд жилийн дундаж өсөлт (CAGR) нь 10.1%-тай байв.

Системийн нөлөө бүхий банкуудын НИЙТ ЭХ ҮҮСВЭР

2022 оны жилийн эцсийн байдлаар банкуудын нийт эх үүсвэрийн 37 их наяд төгрөг буюу 90.3%-ийг системийн нөлөө бүхий том 5 банкуудын эх үүсвэр бүрдүүлж байна.

Үүнээс нийт эх үүсвэрээрээ хамгийн том нь 13.4 их наяд төгрөгийн эх үүсвэртэй Хаанбанк байгаа юм.

Сүүлийн таван жилийн хугацаанд системийн нөлөө бүхий банкуудын эх үүсвэрийн хэмжээ тасралтгүй өсч 25.6 их наяд төгрөгөөс 44.4%-иар өсч 37.0 их наяд төгрөгт хүрсэн байна.

Системийн нөлөө бүхий банкуудын нийт эх үүсвэр, их наяд төгрөг

